

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ШУУРХАЙ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2019 оны 6 дугаар сарын 24-ний өдөр

№ 18

Дархан-Уул аймаг

Аймгийн Засаг даргын Шуурхай хурал 2019 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 08 цаг 00 минутад аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын зааланд хуралдав. Хуралдааныг аймгийн Засаг дарга С.Насанбат удирдаж, хуралд нийт 18 удирдах албан тушаалтнууд оролцохоос 14 оролцож хуралдааны ирц 77.7 хувьтай байв. Гишүүдийн ирцийн бүртгэлийг хавсаргав.

ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. Хэлтэс, алба, сумдын дарга нарын өнгөрсөн 7 хоногийн ажлын тайлан, холбогдох шуурхай мэдээ, мэдээллийг танилцуулах, өмнөх шуурхай хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийн талаарх мэдээ, тайланг танилцуулах.

Хуралд оролцсон хэлтэс, албад, сумдын дарга нар өнгөрсөн 7 хоногт хийсэн ажлын тайланг танилцуулав.

ҮҮРЭГ, ДААЛГАВАР:

С.Насанбат: ТЗУХ-ийн мэргэжилтэн Х.Золжаргал удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хангалтгүй биелүүлсэн, уулзалт хурлын зарыг аймгийн Ерөнхий прокурорт хүргээгүй, зар хүргэсэн гэж удирдлагыг ташаа мэдээллээр хангасан зэрэг асуудал удаа дараа гаргаж, гомдол ирсэн тул сахилгын арга хэмжээ авах /ТЗУХ/

Мөн Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн хэлэлцүүлгийн зарыг ХЭЗХ хүргэхдээ Ерөнхий прокурорт хэлээгүйн улмаас тухайн хүн хэлэлцүүлэгт хоцорч ирсэн. Ийм байдлаар зар тараах энгийн ажлыг хийж чадахгүй байгаа бол бичиг цаасны ажлаа хийж чадах юм уу? Цаашдаа анхаарах хэрэгтэй. /ХЭЗХ/

Ажил явж байгаа. Харж байгаа. Би Ерөнхийлөгчтэй уулзах гэж байгаа тул баатар, гавьяатуудын нэр, материалыг бэлдээд өгөөрэй гэж удаа дараа хэлсэн. Одоо хүртэл надад өгөөгүй. Та нар өөр сувгаараа хөөцөлдөж байгаа бол би юм хэлэхгүй. Баяр наадам дөхөж байхад хэдэн ахмадууд шагналаа авчихвал /Хонгор сум/

Төмөртэй хүнийг нүүлгэх асуудлаар Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр ХК-аас чиглэл хүссэн. Яаж шийдэх гэж байгаа вэ? Тэдний ярьж байгаагаар нааш нь татаад Дархан хаалга дээр авч ирэх санал гаргасан. Судлаад эргээд хариу өгөөрэй. /Э.Равжаадэлгэрэх, Д.Ганбаяр/

Өчигдөр 3-р багийн иргэдтэй уулзалт хийсэн. Иргэдээс цэвэрлэх байгууламжийн үнэр гэр хороолол руу орж ирээд амьдрах орчинд сөргөөр нөлөөлж байгаа гэсэн гомдол ихээр гарсан. Цэвэрлэгээг хийхгүй бохиоор нь усаа гадагшлуулж байна гэсэн мэдээлэл ч өгсөн. Өнөөдөр хүн явуулж газар дээр нь шалгуулах шаардлагатай байна. Яагаад бохирын үнэр нэмэгдэх болов? Үнэхээр цэвэрлэхгүй байгаа юм уу? Эсвэл засвар шинэчлэлтийн ажил хийгдэж байгаа болохоор ингээд байна уу? /Захирагчийн ажлын алба/

Өнөөдөр паркийн тоглоомын угсралтыг хариуцаж байгаа Алдар ирнэ. Суурь цутгасан Дархан Минж ХХК-аас ямар бичиг баримт авах юм бэ? Тоглоомын суурилуулалтын баталгаан дээр Дархан Минж ХХК, угсралтын баталгаан дээр Алдар зурна. Баталгаа зурна гэсэн дээр нь зуруулаад аваарай. Юун дээр зуруулахаа бэлдээрэй. /ХОХБТХ, ОНӨГ/

Сургууль, цэцэрлэгийнхэн амрах гэж байна. АТГ-аас бичиг ирсэн. Одоо биелэлтийг нь хангуулахгүй бол 9 сар ойрхон. Үдийн цай хөтөлбөр эхлэх ёстой. Одоо материалыг нь авч зарлаж, шалгаруулахгүй бол эрхлэгч нар нь амарлаа шүү. /ОНӨГ/

ҮАБЗ-ийн ажлын хэсэг ажиллаад явлаа. ҮАБ-ын чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг хагас жил бүрт зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ гэсэн заалттай гэж зөвлөсөн. Шалгалт болохоор шалгуулдаг биш, ажлуудаа цэгцэлж явмаар байна. Авторали манай аймгаас эхэлнэ гэж ярьж байна лээ. 500 гаруй авто машин, хүнд даацын машин, 19 онгоц ниснэ гэсэн. Манайхаас цэнэглэнэ гэж мэдээлэл ирсэн. Энэ асуудлыг Тагнуул, ҮАБЗ-ийн ажлын хэсэгт мэдээлмээр байна. Манай колонк дээр цэнэглэж байгаад тэсэрч

дэлбэрвэл яана. Том оврын машинуудыг заавал хотын дундуур явуулах хэрэгтэй юм уу? Аюулгүй байдлыг нь яаж хангах вэ? Энэ асуудлыг ҮАБЗ-өөс тодруулмаар байна. /ХЭЗХ/

5 дугаар багийн Засаг даргатай холбоотой харилцааны асуудлаар гомдол санал их ирж байна. Удаа дараа гаргаж байна. Хүнтэй харилцаж чаддаггүй юм уу? Яагаад нэг дарга дээр удаа дараа гомдол гараад байгаа юм бэ? Анхаараарай. /Дархан сум/

СӨХ-ын ажлыг явуулахад багууд онцгой анхаармаар байна. Уралдааныг нь 9 дүгээр сард дүгнэнэ. /Дархан сум/

Айлын хаалга цохиод ус, дулаан, хогны мөнгөө нэхдэг байдлыг 2020 онд шинэчилмээр байна. Арилжааны банктай нөгөө талаас НААҮГ, Ус, Дулаан, СӨХ-тэйгээ хамтарсан гэрээ байгуулаад хураамжаа татдаг больё. Арилжааны банк нь програмаа зохиохоор ярья. Төрийн байгууллагуудаасаа эхэлье. /Дархан сум/

Морь барианы газрын дээвэр хуураад унасан байсан. Засаарай. /Захирагчийн алба/ БНСУ-аас ирсэн 2 түргэний машиныг ОНӨ-т бүртгэж аваарай. /ОНӨГ/

Хүүхдийн номын ордонд хуваарилагдсан машиныг тохижуулах ажлыг манай Тамгын газар хариуцна. НБХ-ийн дарга Н.Цасчихэр Хүүхдийн номын ордны даргыг дуудаж уулзаад саналыг нь аваад тохижуулах ажлыг хариуцаарай. /НБХ/

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТЭС